



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/196

Хэрлэн сум

Бэлчээрийн хөнөөлт мэрэгч
амьтантай тэмцэх ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.6 дахь заалт, Засгийн газрын 2019 оны Бэлчээр хамгааллын ажлыг эрчимжүүлэх тухай 185 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 02 сарын 24-ны өдрийн А/96 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ургамал хамгаалал эрдэм шинжилгээний хүрээлэнгийн бэлчээрийн хөнөөлт мэрэгч үлийн цагаан оготны тодотгох судалгаагаар их хэмжээгээр тархсан 11 сумын 634,3 мянган га бэлчээрт микробиологийн аргаар тэмцэх хаврын ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 30 хоног, “Энгийн механик, биологийн” аргаар мэрэгч амьтантай тэмцэх намрын ажлыг 2024 оны 10 дугаар сарын 05-ээс эхлэн 30 хоногийн хугацаанд тус тус зохион байгуулсугай.

2. Сумдын бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай “Микробиологийн аргаар” болон “Энгийн механик, биологийн” аргаар тэмцэх талбайн хэмжээг 1 хавсралтаар баталсугай.

3. Мэрэгч амьтантай тэмцэх ажлын гэрээ байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, ажлын гарын авлага шаардлагатай техник хэрэгслээр хангаж, сургалт явуулах ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Ж.Энх-Амгалан)-д, тэмцэх ажилд иргэд малчид, малчдын бүлэг хоршоо, сумын мэргэжлийн ангийг хамруулж тэднийг мэрэгчтэй тэмцэх бэлтгэл зохион байгуулалтын арга хэмжээг авч, хууль, журмын дагуу хяналт тавьж ажиллахыг холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн нийтийг хамарсан ажилд орон нутгийн ажилгүй иргэдийг түр ажлын байраар хангаж ажиллахыг Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга (Э.Хонгорзул)-д даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Э.Мөнх-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
..... дугаар сарын-ны өдрийн
..... дугаар захирамжийн хавсралт

УЛИЙН ЦАГААН ОГОТНОТОЙ ТЭМЦЭХ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ

№	Сумын нэр	Тэмцэх шаардлагатай талбайн хэмжээ /мян.га /	Хавар тэмцэх талбай /мян,га/	Микробиологийн бэлдмэл /тн/	Намар тэмцэх талбай /мян,га/
1	Галшар	80000			5,0
2	Баянмөнх	63334	2,0	3,0	6,0
3	Дархан	50000	3,0	4,5	
4	Баян-Овоо	79000	3,0	4,5	6,0
5	Батноров	50000	3,0	4,5	6,0
6	Норовлин	40000			8,5
7	Жаргалтхаан	62000			8,5
8	Цэнхэрмандал	20000	2,0	3,0	
9	Дэлгэрхаан	55000	3,0	4,5	
10	Мөрөн	65000	1,0	1,5	
11	Хэрлэн	70000	3,0	4,5	
	Дүн	634334	20,0	30,0	40,0